



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023-09-20 № ХМ/дод3
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2023 оны 01/5127 дугаар албан бичгийг хүргүүлж байна. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээнд мөрдүүлэх хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг дэмжиж, өөрийн эрхэлсэн салбарын хэмжээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 15 бүлгийн 52 стандартыг мөрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, ажиллахыг хүсье.

Хавсралт 1-хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235021509



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

2023.08.16 № 01/5127

танай _____-ны № _____-т

Хүсэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3-т “нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батална”; мөн Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-д “Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно” гэж тус тус хуульчилсан болно.


Дээрх хуулиудыг үндэслэн нийслэлийн иргэд эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын шаардлагыг хангах зорилгоор нийт 15 бүлгийн 52 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Яамд, засгийн газрын агентлаг, холбогдох бусад төрийн байгууллагуудын нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээнд дээрх 52 төрлийн хотын стандартыг мөрдүүлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлж, хамтран ажиллахыг хүсье.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 15 бүлгийн 52 хотын стандартыг <https://standard.ub.gov.mn/standards> холбоосоор татаж авч, танилцах боломжтой.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



23/7727
1110202039